



WEAR MASK



WASH HANDS



KEEP DISTANCE



УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД



MILLENNIUM
CHALLENGE CORPORATION
UNITED STATES OF AMERICA

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (02)

2021.01.11

"UB ENGINEERING" ТӨСЛИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Улаанбаатар хотын хот нийтийн аж ахуй, инженерийн хангамжийн ашиглалтын байгууллагуудыг нэгдсэн системд оруулах "UB ENGINEERING" төслийг эхлүүлсэн талаар Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр мэдээллээ. Дээрх төслийн хүрээнд хот нийтийн аж ахуй, инженерийн хангамжийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, их болон урсгал засвар, гэнэтийн осол саатал, аж ахуйн өдөр тутмын мэдээллийг шуурхай солилцох ажиллагааг нэгтгэх зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хэлтсүүд болон гүйцэтгэгч "ICT" группийн төлөөллийн хамтарсан эхний уулзалтыг зохион байгуулсан байна. Уулзалтаар төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх байгууллагатай хамтарсан уулзалтыг зохион байгуулж, мэдээллийг түргэн шуурхай солилцох хуваарь, төлөвлөгөөг баталжээ. Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт, удирдлагын систем буюу "UB Engineering"-ийн талаархи мэдээллийг Инженерийн байгууламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Балдандорж болон гүйцэтгэгч "ICT" группийн удирдлагууд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн шуурхай зөвлөгөөн дээр мөн танилцуулсан байна.

[Эх сурвалж: Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба](#)

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ДЭД САЙД Э.ЗОЛБОО ТУУЛ 1 КОЛЛЕКТОРЫН 4-Р ЭЭЛЖИЙН ШУГАМЫН ХЭСЭГТ АЖИЛЛАВ



Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоогоор ахлуулсан ажлын хэсэг БХБЯ-ны ХБГХБХЗГ-ын дарга Ц.Баярбат, НААБЗХГ-ын Г.Цогтсайхан нар 2021 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр Туул 1 коллекторын 4-р ээлжийн шугамын хэсэгт ажиллалаа. Туул коллектор нь Улаанбаатар хотын бохир усны шугамын ачааллыг авах гол шугам бөгөөд одоо байгаа болон ирээдүйд баригдах барилга байгууламжийн бохир усыг татан зайлуулах стратегийн чухал ач холбогдолтой инженерийн шугам сүлжээ юм. Тухайн хэсэгт одоогийн байдлаар бохир усны шугам угсралтын 1100 метр урттай шугамын угсралт, бохир усны худаг 8 ширхэг худаг хийсэн байна. Улаанбаатар хотын бохир усны Туул 1 коллекторын хамгаалалтын зурвас газрын газар чөлөөлөлт, шугамын угсралтын ажлын явц, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Тус ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай нэмэлт хөрөнгө мөн газар чөлөөлөлтийн асуудлыг нарийвчлан судлаж, шийдвэрлэн шугам сүлжээний угсралтын ажлыг эрчимжүүлэн ажиллахаар болов.

[Эх сурвалж: БХБЯ-ны Фэйсбүүк хуудас](#)

НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ИНСТИТУЦИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛНЭ



Азийн хөгжлийн банк нь гэр хорооллыг хөгжүүлэх, ус хангамж, ариутгах татуургын хангамж, хүртээмжийг сайжруулах чиглэлд хэд хэдэн төслийг санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа билээ. Тэгвэл эдгээр төсөл хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлэх, тогтвортой хадгалах зорилгоор Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын институцийн чадавхийг бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл хэрэгжүүлэхээр болсон байна. Төслийн саналыг 2020 оны 12 дугаар сарын 4-нд баталсан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хэрэгжүүлэх юм байна. Нийт 750 мянган ам.долларын санхүүжилттэй энэхүү төслийн хүрээнд Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах үр дүнтэй сургалтын механизмыг бий болгох, сургалтын стратегийг боловсруулахад бодлогын зөвлөмж өгөх, техникийн сургалтын төвийн чадавхийг бэхжүүлэхээр зорьж байгаа юм байна. Үр дүнд нь ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна хэмээн тооцжээ. Төслийн дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.adb.org/projects/54008-001/main#project-pds> холбоосоор үзэх боломжтой.

[Эх сурвалж: adb.org](https://www.adb.org)

УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН



01 дүгээр сарын 12-ны Мягмар гарагт:

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаан 14.00 цагаас "Жанжин Д.Сүхбаатар" танхимаас цахим хэлбэрээр хуралдана. Хэлэлцэх асуудал:

- Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай /Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд/;
- Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай /Байгаль орчныг хамгаалах тухай, Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай, Ойн тухай, Усны тухай болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд/.

[Эх сурвалж: parliament.mn](https://parliament.mn)